

## **Морин тээврийн бааз**

1921-7-19-нд Засгийн газрын 6 дугаар хурлаар өртөөний тухай хэлэцээд Хүрээ-улиастай, Хүрээ- хиагтын зэрэг өртөөдөөс олон өртөөдийг хааж, Богдын уяа морийг цөөтгөх, сүм хийдээс бадар барихад өртөө, улаа хэрэглэхийг бүр мөсөн зогсоох, зэрэг олон арга хэмжээ авсны гадна цаашид өртөө улааг улам хорогдуулах, өртөөний албан хаагчдийн цалин хэрэглэлийг улсаас олгох Улаанбаатар–Өндөрхаан, Улаанбаатар-Алтанбулаг, Улаанбаатар-Сулинхэ, Улаанбаатар – Хадаасан зэрэг 57 сурь морин өртөөний замд автомашинаар шуудан зорчигчдийг тээн нэвтрүүлэх болсон зэргээр цаашид олон суурь морин өртөөний албыг автомашинаар гүйцэтгэдэг болгосон.

1949-10-5-наас эхлэн ардын бүх аж ахуйтныг морин өртөөний албанаас чөлөөлж 10 дугаар сарын 1-нээс улсын морин өртөөг байгуулжээ.

1949 оны 10 дугаар сарын 25-наас аймгуудад улсын авто өртөөг байгуулсан байна.